



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН “ХАН-УУЛ
ЗАМ ЗАСВАР, АРЧЛАЛТ”
ОНӨААТҮГ-Т

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.06.27 № 03/5577

танай _____-ны № _____-т

Гомдол хянасан тухай

Танай байгууллагаас зарласан ХУЗЗАОНӨААТҮГ/20240101016 дугаартай “Түргэний гол дээрх төмөр бетон гүүр барих ажил”-ын гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтад оролцсон “ЗЗБ” ХХК-аас гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэг болон Сангийн 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам” (цаашид “журам” гэх)-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох баримт материалд үндэслэн хянан үзлээ.

“ЗЗБ” ХХК-ийн гомдолд тус компанийн тендерээс автотээврийн хэрэгслийн татвар төлөлтийн баримтыг ирүүлээгүй гэж татгалзсан болон захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “ДОИЧ роуд” ХХК-ийн ирүүлсэн тендер нь тендер шалгаруулалтын баримт бичгийн холбогдох шаардлагад нийцэхгүй байх тул захиалагчийн шийдвэрийг хянаж өгөхийг хүссэн байна.

Үнэлгээний хорооны 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 02 дугаар хурлын тэмдэглэлд захиалагчаас ажил гүйцэтгэх хүний нөөцийн асуудал болон ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний үнийн дүнг төсөвт өртгийн 50 хувиар заах талаар санал ирүүлсний дагуу тендер шалгаруулалтын баримт бичигт өөрчлөлт оруулсан талаар тэмдэглэсэн байх бөгөөд тендер шалгаруулалтын баримт бичигт өөрчлөлт оруулсныг худалдан авах ажиллагааны цахим системийн тодруулга хэсэгт 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр нийтэлсэн байна.

Тус тендер шалгаруулалтын тендер хүлээн авах хугацаа 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр гэж заасан бөгөөд тендер шалгаруулалтын баримт бичигт 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр өөрчлөлт оруулсан нь хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсэгт “Захиалагч тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж, цахим системд нийтэлсэн бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.” гэж, 20.7 дахь хэсэгт “Энэ хуулийн 20.6-д заасан тендер нээх хугацаа тухайн нэмэлт, өөрчлөлтийг цахим системд нийтэлсэн өдрөөс хойш ажлын таваас дээш өдөр бол тендер нээх хугацааг сунгахгүй байж болно.” гэж тус тус заасанд нийцсэн байна.

“ЗЗБ” ХХК-ийн гомдолд тендер шалгаруулалтын баримт бичигт өөрчлөлт оруулсан асуудлаар гомдол гаргасан байхад захиалагч хариу өгөөгүй талаар

9766010078

дурдсан байх тул хуулийн 57 дугаар зүйлд зааснаар захиалагч гомдол хянан шийдвэрлэх үүрэгтэй болохыг анхаарна уу.

Гомдолд дурдсан үндэслэлээр “ЗЗБ” ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 16.1.2-ын 3-т “Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: “Шаардана”. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдол, зам ашигласны төлбөр төлсөн баримт /тендерт санал болгосон машин механизмын 2023 оны мэдээллийг тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээ “smartcar.mn”, татварын удирдлагын нэгдсэн систем “etax.mta.mn, itax.mta.mn” систем, “ибаримт” гар утасны аппликэйшн, гэрэгэ киоск, пос терминал төхөөрөмж ашиглан ирүүлэх/. Дээрх материалуудыг тендерт хавсаргаж ирүүлээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.” гэж, ТШЗ 19.1-д “Дээрх хүснэгтэд заасан 9 машин механизмын 7 нь өөрийн эзэмшлийн байх шаардлагатай бөгөөд 2 нь түрээсийн гэрээтэй байж болно. Дээрх машин механизмын эзэмшигчийн талаарх мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-ээр дамжуулан шалгана. Шаардлагатай машин механизмын эзэмшигчийн лавлагаа мэдээллийг ирүүлээгүй болон зөрсөн тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.” гэж тус тус заасан байна.

“ЗЗБ” ХХК худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр нийт 9 машин механизмыг үүнээс өөрийн өмчлөлийн 7, түрээсийн гэрээний дагуу эзэмших 2 гэж ирүүлсэн байна.

Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын 2.5-д “Захиалагч цахим системтэй холбогдсон мэдээллийн сангаас дараах журмаар ирүүлсэн тендер шалгаруулалт зарласнаас хойших мэдээллийг тендер хянан үзэхэд үндэслэл болгоно. Үүнд: 2.5.1.татвар, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт. Уг тодорхойлолтыг оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө цахим системээр дамжуулан авч цахим системийн холбогдох хэсэгт зааварчилгааны дагуу холбосон байх;” гэж заасны дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээс шалгахад “ЗЗБ” ХХК 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн татварын дугаар үлдэгдэлгүй тухай тодорхойлолтыг ирүүлсэн байна.

“ЗЗБ” ХХК хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтад заасан татварын хугацаа хэтэрсэн өргүй байхад тус компанийн ирүүлсэн тендерээс автотээврийн хэрэгслийн татвар төлөлтийн баримт ирүүлээгүй гэж татгалзсан захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна.

Тендер шалгаруулалтын баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 16.3-т “Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.” гэж заасны дагуу Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журмын 2.5-д зааснаар оролцогчийн ерөнхий шаардлагыг хянан үздэг болохыг анхаарна уу.

Гомдолд дурдсан үндэслэлээр захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “ДОИЧ роуд” ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

1.Тендер шалгаруулалтын баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 14.1-д “Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.” гэж заасны дагуу худалдан авах ажиллагааны цахим системээс шалгахад “ДОИЧ роуд” ХХК тендер илгээх 1 дүгээр маягтыг тоон гарын үсгээр баталгаажуулж ирүүлсэн байна. Тус маягтын 2-т “Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцохтой холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна. Үүнд: 2.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;” гэж заасан байх тул хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан нөхцөл үүссэн эсэх тухай мэдэгдэл ирүүлээгүй гэх гомдол үндэслэлгүй.

2.Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.2-ын 2-т “Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагыг нотлох дараах баримт бичиг ирүүлнэ. Үүнд:-2021, 2022, 2023 онд гэрээгээр гүйцэтгэсэн ажлын ижил төстэй ажилд тооцуулахаар санал болгосон гэрээт ажлын гэрээ, ажил хүлээлгэж өгсөн улсын комиссын акт, гүйцэтгэл нь бүрэн чанартай байсан талаарх өмнөх захиалагчийн тодорхойлолт зэрэг баримт бичгийн хуулбарыг ирүүлнэ. (Комиссын дүгнэлтийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан баталгаажуулсан байна.)” гэж тус тус заасан байна.

“ДОИЧ роуд” ХХК-аас ижил төстэй гэрээний туршлагад ирүүлсэн “Heilogjiang Jinyi Road and Bridge Co., Ltd” компанитай 2019 онд байгуулсан замын ажил гүйцэтгэх гэрээнд холбогдох захиалагчийн 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн HL-06/30 дугаартай Дархан-Уул аймгийн Тамгын газар, Орон нутгийн өмчийн газарт хандсан захиалагчийн тодорхойлолтыг тендерт хавсаргаж ирүүлсэн байна.

Тодорхойлолтыг захиалагчид хаяглан ирүүлэх талаар тендер шалгаруулалтын баримт бичигт заагаагүй тул дээр дурдсан өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.2-ын 2-т заасан “гүйцэтгэл нь бүрэн чанартай байсан талаарх өмнөх захиалагчийн тодорхойлолт” гэсэн шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

3.Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д “Ажил гүйцэтгэх хүний нөөц: Шаардана. 1.Ерөнхий инженер нь авто замын инженер, зөвлөх буюу мэргэшсэн зэрэгтэй байх; 2.Гүүр, хиймэл байгууламжийн инженер нь Авто замын инженер, Гүүр, хиймэл байгууламжийн инженер байх.” гэж, ТШЗ 19.2-т “Тендерт оролцогчийн үндсэн ажилтан, хөлсөөр ажиллах гэрээний дагуу ажиллах ажилтны мэдээллийг цахим систем дэх V бүлэгт заасан маягтаар зааварчилгааны дагуу санал болгоно. Цахим системээр санал болгоогүй тохиолдолд хянан үзэхгүй. Бусад мэргэжилтэй ажиллах хүчний тухайд гэрээт ажилтан байж болох бөгөөд хөдөлмөрийн гэрээ, хөлсөөр ажиллах гэрээг хавсаргаж ирүүлнэ. Инженер, техникийн болон бусад мэргэжлийн ажилтнуудын иргэний үнэмлэх, диплом, нийгмийн даатгал төлсөн лавлагааг дээрх хугацаагаар төрийн мэдээллийн сангийн www.e-mongolia.mn сайтаас татан авч ирүүлнэ. Ирүүлсэн баримт бичгийн хүчинтэй хугацаа дуусаагүй байна. Хэрэв хүчинтэй хугацаа дууссан тохиолдолд уг баримтыг хүчингүйд тооцож тендерээс татгалзах үндэслэл болно.” гэж тус тус заасан байна.

3.1.“ДОИЧ роуд” ХХК-аас худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д Г.Идэрбатыг ерөнхий инженерт санал болгож, түүний мэргэшсэн инженерийн ЗМИ-192-18 дугаартай гэрчилгээг ирүүлсэн байх бөгөөд уг гэрчилгээний хүчинтэй байх хугацаа 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдөр гэж тэмдэглэсэн байна.

Тус тендер шалгаруулалтын тендерийн нээлт хийсэн 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ерөнхий инженерт санал болгосон Г.Идэрбатын мэргэшсэн инженерийн гэрчилгээний хүчинтэй байх хугацаа дуусгавар болсон байх тул дээр дурдсан өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.2-т заасан “Ирүүлсэн баримт бичгийн хүчинтэй хугацаа дуусаагүй байна.” гэсэн шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна.

3.2.“ДОИЧ роуд” ХХК-аас худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д Ц.Амартүвшинийг Авто зам, гүүрийн инженерт санал болгосны дагуу захиалагч түүний дээд боловсролын дипломын мэдээллийг цахим системээс шалгахад “580700 Авто замын барилга” мэргэжлээр Шинжлэх ухаан, технологийн их сургуулийг 2004 онд бакалаврын зэрэгтэй төгссөн тухай дипломын тодорхойлолт татагдсан байна.

Авто зам, гүүрийн инженерт санал болгосон Ц.Амартүвшин дээр дурдсан өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д заасан “2.Гүүр, хиймэл байгууламжийн инженер нь Авто замын инженер, Гүүр, хиймэл байгууламжийн инженер байх.” гэсэн шаардлагад нийцэх эсэхэд захиалагч үнэлгээ хийгээгүй байна.

3.3.“ДОИЧ роуд” ХХК-аас нийт 10 мэргэжлийн ажилтны мэдээллийг тендерт ирүүлсэн байх бөгөөд оператор С.Отгонбаяр нь тус компанийн ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн НД-8 маягтад “01001” кодтой даатгуулагчийн төрлөөр бүртгэгдсэн байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2024 оны А/44/А/40 дүгээр хамтарсан тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн анхан шатны бүртгэлийн маягт хөтлөх аргачлал”-д “01001” даатгуулагчийн төрлийн код нь “Хөдөлмөрийн гэрээний дагуу ажиллаж байгаа үндсэн ажилтан” байх тул хөдөлмөрийн гэрээг хавсаргаж ирүүлэх шаардлагагүй байна. “ДОИЧ роуд” ХХК-аас хөдөлмөрийн гэрээ хавсаргаагүй тухай гомдол үндэслэлгүй.

Харин бусад мэргэжлийн ажилтанд холбогдох хөлсөөр ажиллах гэрээг тендерт хавсаргаж ирүүлээгүй нь дээр дурдсан өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.2-т заасан “Бусад мэргэжилтэй ажиллах хүчний тухайд гэрээт ажилтан байж болох бөгөөд хөдөлмөрийн гэрээ, хөлсөөр ажиллах гэрээг хавсаргаж ирүүлнэ.” гэсэн шаардлагад нийцэхгүй байна.

4.Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д “Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: Шаардана. 2.Автогрейдер /250м.х/, 3.Ачигч /1.0м3/, 5.Өөрөө буулгагч /20 тонн-с дээш/, 7.Авто кран /25 тонн-с дээш/. Санал болгосон техникийн хүчин чадал дээрх хүснэгтэд зааснаас багагүй байх. /Машин механизмын хүчин чадал хүснэгтэд зааснаас бага тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно./

4.1.“ДОИЧ роуд” ХХК-аас худалдан авах ажиллагааны цахим системд ирүүлсэн 7259УБ улсын дугаартай Автогрейдер “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын авто тээврийн үйлчилгээний мэдээллийн санд PУ, 180G 6400 CC гэж бүртгэгдсэн тул 180м/х хүчин чадалтай байгаа тухай гомдолд дурдсан асуудлыг захиалагч хянан үзэх шаардлагатай байна.

4.2.“ДОИЧ роуд” ХХК-аас худалдан авах ажиллагааны цахим системд ирүүлсэн 2026УР улсын дугаартай Авто ачигч “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын авто тээврийн үйлчилгээний мэдээллийн санд Shandong, L930 0 CC загварын авто ачигч нь “шанаганы багтаамж: 0.8м/куб, хэмжээ:5460*1900*2800мм, шанаганы даац:2000кг” гэж бүртгэгдсэн байх тул шанаганы багтаамж 0.8м/куб байгаа тухай гомдолд дурдсан асуудлыг захиалагч хянан үзэх шаардлагатай байна.

4.3.“ДОИЧ роуд” ХХК-аас худалдан авах ажиллагааны цахим системд ирүүлсэн 1630УНГ улсын дугаартай өөрөө буулгагч “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын авто тээврийн үйлчилгээний мэдээллийн санд Howo, ZZ3257N3847E1L 9726 CC, Өөрийн жин: 15400 Кг, Даац: 15600 Кг гэж бүртгэгдсэн байх тул даац нь “20 тонн-с дээш” байх шаардлагад нийцээгүй асуудлыг захиалагч хянан үзэх шаардлагатай байна.

4.4.“ДОИЧ роуд” ХХК-аас худалдан авах ажиллагааны цахим системд ирүүлсэн 4883УНЯ улсын дугаартай автокран “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын авто тээврийн үйлчилгээний мэдээллийн санд XCMG, QY20B 9726 CC, даац:20тн гэж бүртгэгдсэн байх тул даац нь “25 тонн-с дээш” байх шаардлагад нийцээгүй асуудлыг захиалагч хянан үзэх шаардлагатай байна.

5.Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д “Түрээсээр ашиглах бол түрээсийн гэрээг улсын дугаарыг харуулсан фото зургийн хамт ирүүлнэ. Дээрх хүснэгтэд заасан 9 машин механизмын 7 нь өөрийн эзэмшлийн байх шаардлагатай бөгөөд 2 нь түрээсийн гэрээтэй байж болно. Дээрх машин механизмын эзэмшигчийн талаарх мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-ээр дамжуулан шалгана. Шаардлагатай машин механизмын эзэмшигчийн лавлагаа мэдээллийг ирүүлээгүй болон зөрсөн тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.” гэж заасан байна.

“ДОИЧ роуд” ХХК худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр нийт 9 машин механизмыг үүнээс өөрийн өмчлөлийн 7, түрээсийн гэрээ (4734УБ улсын дугаартай индүү, 0948УАО улсын дугаартай автосамасвал)-ний дагуу эзэмших 2 гэж ирүүлсэн байна. 4734УБ улсын дугаартай индүүний фото зургийг ирүүлсэн ч улсын дугаар харагдахгүй байгаа нь дээр дурдсан өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д заасан “Түрээсээр ашиглах бол түрээсийн гэрээг улсын дугаарыг харуулсан фото зургийн хамт ирүүлнэ.” гэсэн шаардлагад нийцэх эсэхэд захиалагч үнэлгээ хийгээгүй байна.

Иймд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.1 дэх заалтыг үндэслэн захиалагчийн 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 182, 184 тоот шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэж байна.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.3 дахь заалтад үндэслэн тендер шалгаруулалтын тендерийн үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг мэдэгдье.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: "ЗЗБ" ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Ж.ГАНБАТ